



ТӨРИЙН
АУДИТ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020 - 11 - 27 № 4442

төвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлт

Г. БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН
төлөөлөгчдийн хурлын дарга
д. ЭРДЭНЭБАТ ТАНАА

Г. Аудитын дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газраас Булган аймгийн төсвийн өрөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн төслийн дүгнэлтийг хүргүүлэв.

Хавсралт.... хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
НЭГ. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА, ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ.....	4
ХОЁР. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	6
ГУРАВ. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ.....	8
ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	8
ТАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ.....	12
ХАВСРАЛТ.....	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХЖТ	Хөгжимт жүжгийн театр
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "... аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх," гэсэн заалтыг үндэслэн дүгнэлт гаргалаа.

Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай зэрэг хуулиудын холбогдох зүйл, заалт, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол зэрэг холбогдох эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгов. Тухайлбал:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтууд, 5 дугаар зүйлийн 5.1 дахь зарчим, 9 дүгээр зүйлийн 9.10 дахь "Аймаг, нийслэлийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг" зэрэг заалтуудыг баримталсан эсэх,

2."Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдсан эсэх,

3.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь төсөвлөлтийн шаардлагад нийцсэн эсэх.

Аймгийн СТСХ 2021 оны төсвийн төслийг боловсруулахдаа орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэсэн, зарлагыг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчим, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчин, заавар журмын хүрээнд статистик тоо мэдээ, үнэ ханш зэрэг өөрчлөлтүүд, урсгал төсвийн зарлагын шинэчлэлийг тусган тооцоолж боловсруулжээ.

НЭГ.ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦСЭН ЭСЭХ:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дугаар зүйлийн 6.10.4 дэх "Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх." гэсэн заалтын дагуу мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь "Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", 4.1.9 дэх "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр", 4.1.12 дахь "Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө"-тэй харьцуулж үзэх гэсэн боловч дээрх баримт бичгүүд орон

нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгийн хугацаанаас шалтгаалан батлагдах шатандаа энэ цаг хугацаанд хэлэлцэгдэж байна.

ХОЁР. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ

2.1 Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн төсөлд татвар нэмэхгүйгээр бизнесийг дэмжих төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэн боловсруулжээ.

2.2 Орон нутгийн төсвийн нийт орлогыг 64627.3 сая төгрөг үүний 23,566.0 сая төгрөг ургал орлого байхаар төлөвлөсний 95.9 хувийг татварын орлогоос, 3.9 хувийг татварын бус орлогоос, 0.1 хувийг хөрөнгийн орлогоос бүрдүүлэхээр тооцжээ.

2.3 Тусlamжийн орлогыг 41364.3 сая төгрөг байхаар төлөвлөсний 6.8 хувийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, 9.8 хувийг улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлгийн орлого, 83.4 хувийг улсын төсвөөс орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага эзэлж байна.

2.4 Төсвийн орлогыг Улсын Их Хурлаас баталсан суурь орлогоос төсөвт байгууллын өөрийн орлогыг 46.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2.5 Булган аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн төсөлд зарим төсвийн орлогын эх үүсвэрийг дайчлан орлого нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

- Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн тоо Автотээврийн үндэсний төвийн Булган салбарын бүртгэлээр 17192, татварын хэлтсийн бүртгэлээр 10732 байгаа нь 136.8 сая төгрөгийн автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого төвлөрүүлэх боломж байна. Иймд төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.
- Галт зэвсгийн албан татварын орлогыг 1328 галт зэвсгээс 54.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон нь Цагдаагийн газрын бүртгэлээс 492 галт зэвсгээр дутуу буюу 19.8 сая төгрөгийг дутуу тооцсон байна.
- Хүү торгуулийн орлогыг 2020 онд 408.7 сая төгрөгөөр төлөвлөн хагас жилийн байдлаар 426.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Цагдаагийн газар 2017-2019 онд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 63573 жолоочид 2016.2 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Харин 2020 онд 24582 жолоочид 909.8 сая төгрөгийн торгууль оногдуулснаас 235.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 674.8 сая төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт

- Үнэн зөв тоо баримтад тулгуурлан орлогыг оновчтой төлөвлөн тодорхой арга хэмжээг зохион байгуулж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан

ажиллаж дээрх дутуу төлөвлөсөн орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

ГУРАВ. АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

3.1 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 64627.3 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оноос 1634.9 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар бууруулан тооцжээ. Оны эхний үлдэгдэл болон төсөвт байгууллагын өөрийн орлого нийт 1373.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 66001.1 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгасан байна.

3.2 УИХ-аас баталсан дүнгээс дараах байгууллагуудын төсөвт өөрчлөлт оруулан төсвийн төсөлд тусгасан байна. Тухайлбал:

Аймгийн ИТХ 393.4, сумдын ИТХ 138.8, аймгийн ЗДТГ 201.3, сумдын ЗДТГ 34.8, Хот тохижуулах анги 110.0, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 272.3, тогтмол зардалд ЕБС-д 177.1, сумдын ЭМТ-үүдэд 159.0, Соёлын төвүүдэд 14.3, авто замын санд 60.0, сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн, Ойн аngiудаас 7.6, байгаль хамгаалах сангаас 280.4, Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 5.6, Орон нутгийн өмчийн газраас 13.8, Номын сангийн 5.3, ХЖТ-ын 65.9, БТСГ-ын 56.7 сая төгрөгийг тус тус бууруулсан.

3.3 Зарим байгууллагуудын төсөвт эдийн засгийн ангиллаар өөрчлөлт оруулсан, нэмэгдүүлсэн зардлыг авч үзвэл аймгийн ИТХ-ын төсвийг цалин, нэмэгдэл, урамшууллын зардал 119.2, урсгал засварт 19.1, багаж техник хэрэгсэл худалдан авахад 15.3, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 66.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, төлөвлөгөөгүй ажил олгогчийн нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 134.1, гадаад албан томилолтод 10.0, орон байраар хангахад дэмжлэг үзүүлэхэд 10.0, тавилга хэрэгсэл худалдан авахад 1.1, хог хаягдалд 1.0, ном хэвлэлд 0.4 нийт 393.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тусгасан байна.

3.4. Мөн аймгийн ЗДТГ-ын төсвийг хичээл үйлдвэрлэлийн дадлагад 86.0, ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 40.0, зочин төлөөлөгч хүлээн авахад 35.0, багаж, техник хэрэгсэлд 23.5, тээвэр шатахуунд 20.9, тавилга эд хогшилд 15.0, гадаад албан томилолтод 10.0, баяр наадмын зардалд 10.0 зэрэг нийт 201.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тусгажээ.

3.5 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зарлагын 88.9 хувийг урсгал зардал, 11.1 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Дүгнэлт:

- Урсгал зардлын 2017-2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад дунджаар цалин хөлс 213.0, түлш халаалт 82.0 норматив зардал 50.1, бараа үйлчилгээний бусад зардал 1005.4 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс үзэхэд төсвийн захирагчид төсвийг төлөвлөхдөө тогтоосон тариф, үнэ, норм нормативыг

баримталдаггүй, үндэслэлгүй тооцож байгааг харуулж байна. Төлөвлөлтийг тооцоо судалгаатай хийснээр зардал буурах боломж байна.

- Дэлхий нийт, улс, орон даяар “Covid-19” цар тахал дэгдсэн, улс, орон нутгийн хэмжээнд эдийн засаг, санхүүгийн хүндрэл үүсэж болзошгүй нөхцөлд орон тоо нэмэх, тавилга, эд хогшил бэлтгэх, гадаадад албан томилолтоор ажиллах, хичээл үйлдвэрлэлийн дадлагад хөрөнгө зарцуулахаар байгаа нь тэвчиж болох зардлыг багасгах талаар санаачилга гаргаагүй байна.

ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

4.1 Аймгийн орон нутгийн хөгжлийн санд өмнөх оноос шилжиж ирсэн 6 ажилд 631.5, энэ онд шинээр эхлэх 2669.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажилд 1612.1, орон нутгийн 2 суурь зардалд 534.3, сумдын ОНХС-д 1282.7 нийт 6255.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд 4060.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

4.2 Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн XV хуралдаанаар аймгийн 2020 оны төсөвт өөрчлөлт оруулахдаа Могод сумын ЗДТГ-ын барилга, Бүрэгхангай сумын дотуур байрны өргөтгөл, Тэшиг сумын Цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг 2020-2021 онд санхүүжүүлэхээр тусгасан,

4.3 Гурванбулаг сумын Соёлын төвийн барилгын засвар, Булган сумын 1-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт, Могод сумын сургуулийн Б блокийн засварын ажлуудыг 2020 онд санхүүжүүлж дуусгахаар төлөвлөсөн боловч орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт дутуу ирснээс шалтгаалан 2021 оны төсөвт 3 ажил шилжих байтал 6 ажил шилжиж 631.5 сая төгрөг төлөвлөхөөр шилжүүлсэн,

4.4 Байгаль хамгаалах санд өмнөх оноос шилжиж ирсэн 2 ажилд 844.5, энэ онд шинээр усны нөөцийг хамгаалах, усан хангамжийг сайжруулах 13 ажилд 2423.7, ой, цөлжилтийн 7 ажилд 712.8, газар, газрын хэвллийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах 4 ажилд 142.5, биологийн төрөл зүйлийг хамгаалах 7 ажилд 148.4 нийт 4271.9 сая төгрөгийг зарцуулахаар тусгажээ.

4.5 Аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тооцож үзэхэд ус ашигласны төлбөрийн орлогоос байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан ус ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг усны, газрын нөөцийн төлбөрийн орлогын 15 хувийг газрын, ойн нөөц ашигласны орлогын 85 хувийг ойн, ан агнуурын орлогын 50 хувийг ан агнуурын нөөцийг нөхөн сэргээхэд тус тус зарцуулна гэж заасан журмын хувь хэмжээгээр тооцоход 5458.6 сая төгрөгийг байгаль, орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд төлөвлөхөөр байгаа ч Сангийн яамнаас 4552.3 сая төгрөгийг төлөвлөсөн нь 1352.2 сая төгрөгийг дутуу төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Дээрх заалтаар байгаль хамгаалах сангийн хөрөнгийн хуваарилалтыг хүснэгтээр тооцож үзвэл:

№	Нөөц ашигласны төлбөрийн төрөл	Доод хязгаарын хувь	Орлогын дүн /сая.төг/	Доод хязгаараар тооцсон дүн /сая.төг/	Байгаль хамгаалах чиглэлээр болон эдийн засгийн ангиллаар төсөлд тусгасан /сая.төг/	Зөрүү
1	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого	15	1	0.15		-0.15
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50	5	2.5	10	7.5
3	Газрын нөөцийн төлбөрийн орлого	15	670	100.5	987	886.5
4	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85	330	280.5	712.8	432.3
5	Үс, рашаан ашигласны төлбөрийн орлого	35	14500	5075	2423.7	-2651.3
Нийт дүн			15506	5458.65	4133.5	-1325.2

Эх сурвалж: Булган аймаг дахь Төрийн аудитын газар

4.6 Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 2019, 2020 онд 743.4 сая төгрөг төлөвлөснөөс 10.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан ч 2021 оны төсвийн төсөлд 670.0 сая төгрөг тусгаж хэрэгжүүлэхээр тусгасан нь төлөвлөгдсөн ажил хугацаандаа хийгддэггүй, төсөвт өртөгт өөрчлөлт ордог нь ажлын хариуцлагатай холбоотой байгааг харуулж байна.

4.7 Аймгийн 2021 оны төсвийн төсөлд зарим хөрөнгө оруулалтыг хасах, зардлыг бууруулах боломж байна. Үүнд:

- Ойн хортны тэмцлийн ажлыг Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Сайхан, Баян-Агт, Бугат, Орхон, Сэлэнгэ сумын 30800 га-д 400.8 сая төгрөгөөр хийхээр төлөвлөснийг 2020 онд мэргэжлийн байгууллага 12000 га-д гэрлэн урхи, 18800 га-д авиамикробиологийн аргаар хийх дүгнэлтэд үндэслэн төлөвлөөгүй, 2020 онд 30000 га-д 280.0 сая төгрөгөөр гүйцэтгэснийг үндэслэн 110.0 сая төгрөгөөр бууруулах нь зүйтэй байна.
- Ойн хортны судалгааны ажилд 30000 га-д 30.0 сая төгрөг төлөвлөснийг 2020 онд 50000 га-д 24.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэснийг үндэслэн 15.0 сая төгрөгөөр бууруулах боломж байна.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас: Саятан хаалганы засвар шинэчлэл, орчны тохижилт 100.0 сая төгрөг төлөвлөсөн нь зураг төсөв, ТЭЗҮ-гүй, орон нутгийн иргэдийн санал аваагүй хөрөнгө оруулалт жагсаалтад тусгасан Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.", Сангийн сайдын 2018 оны 228

дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 3.1.2 дахь "ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх; ", 3.1.3 дахь "ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;" гэсэн заалтуудыг зөрчсөн тул хасах шаардлагатай байна.

- Аймгийн баяр наадмын зардал 60.0 сая төгрөг төлөвлөсөн нь аймгийн баяр наадмын зардлыг ЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолоор баталсан жишиг хэмжээг баримтлан ажиллах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн зарчмыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй байна.

Дүгнэлт :

- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах" заасныг зөрчиж газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 2020 оны төсвийн өөрчлөлтөөр 10.0 сая төгрөгийг тусгаж 2021 оны төсвийн төсөлд 670.0 сая төгрөг тусгасан, Могод сумын ЗДТГ-ын барилгын ажилд 2020 онд 50 сая төгрөгийг тусгаж 2021 онд 150 сая төгрөгийг тусгаж байгаа нь хуулийн шаардлагаас дутуу төсөвлөсөн байна.
- Төсвийн төсөлд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

ТАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- Төрийн аудитын газраас 2020 онд аймгийн ТЕЗ-д харьялагдах 92 байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийхэд 18 нь хязгаарлалттай, 1 байгууллагад татгалзсан санал дүгнэлт авсан, гүйцэтгэл, нийцлийн аудитаар өмнөх онуудад илэрсэн алдаа, зөрчил бүрэн арилдаггүй зэрэгт онцгой анхаарч санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад тавих шат, шатны хяналтыг сайжруулж хариуцлага тооцож ажиллах.
- Орон нутгийн хөгжлийн санд Тогтвортой амьжиргаа-III төслөөс дэмжлэг үзүүлж сайн хэрэгжүүлсэн тодорхой үзүүлэлтээр 2019 онд 6 сум 12.0-18.5 нийт 84.5, 2020 онд 8 сум 8.9-17.4 нийт 117.4, 2021 онд Баян-Агт, Гурванбулаг, Рашаант, Хангал

зэрэг 4 суманд 17.8-19.9 нийт 75.2 сая төгрөгийн урамшуулал олгооор төсөвт тусгасан байгаад дүгнэлт хийж, бусад сумууд ажлаа сайжруулж, орон нутгийн хөгжлийн сангийн журмыг мөрдөн ажиллах шаардлагатай байна. Тухайлбал: Урамшуулалд хамрагдаагүй сумдууд хууль, журам мөрдөөгүйгээс 213.6 сая төгрөгийн төсвийн санхүүжилтийн боломжийг алдсан гэж тооцож болооор байна.

- Орон нутгийн төсвийн байгууллагуудаас зөвхөн аймгийн ЗДТГ нь олон жил ажилласан ажилтнуудад жил бүр нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон сууцны хөнгөлөлт дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Энэхүү дэмжлэгт хөдөө орон нутагт төрийн захиргааны байгууллагад олон жил ажиллаж байгаа албан хаагчдад хамрагдах боломжгүй байгаа хараад АЗДТГ нь давуу байдал үүсгэж төсөвт тусгаж батлуулж байна гэж үзэхээр байна.
- Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга, барилгын өргөтгөл, засварын ажлыг 2-3 жил дамжуулан хийхээр төлөвлөдөг, санхүүжүүлэх боломжгүй байтал эхний жилд бага хэмжээний мөнгө төсөвт тусгуулж дараа жил заавал санхүүжүүлэхээс өөр аргагүйд хүргэдэг хариуцлагагүй тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна.